

## ОХИД ХӨВГҮҮДТЭЙ ХОЛБООТОЙ ЖЕНДЭРИЙН ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТУУД

*П.Түмэнгэрэл доктор*  
*Orcid:0000-0003-2800-716X*  
*МУИС, ШУС, ХУС, ГХТ*  
*Е. Бямбасүрэн*  
*МУИС, ШУС, ХУС, ГХТ*

**Abstract:** *All around us, conversations about gender equality, women's rights, men's and women's work, gender neutrality, female or male names take place every day and become a part of our lives. Over time, as things around us have evolved and flourished, we as humans have come to understand and recognize a variety of people's understandings of gender identity, not just male and female. The issue of male and female sexual roles was mainly studied from the perspective of society and family. There are many studies related to the roles of men and women in Mongolian families and their position in society. Research on the significance of gender in early childhood is scarce. This article has a high theoretical value because it decided to explore the prevailing ideas about gender in childhood.*

**Keywords:** *male, female, sexual roles, gender*

### **Оршил**

Бидний эргэн тойронд жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрх, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажил, хүйсийн төвийг сахих, эмэгтэй эсвэл эрэгтэй нэрс гэх мэт яриа өдөр тутамдаа болж, бидний амьдралын нэгэн хэсэг болдог. Он цагийн эрхээр биднийг тойрон хүрээлэх зүйлс хөгжиж, цэцэглэхийн хэрээр хүмүүс бид дан ганц эр эм хүйс биш, LGBT(ЛГБТ) – лесбиан, гей, бисексуал, трансжендер гэдэг нь эмэгтэй ижил хүйстэн хүмүүс (лесби, Lesbian), эрэгтэй ижил хүйстэн хүмүүс (гей, Gay), эр эм хүйсийн аль алинд нь татагддаг хүмүүс (бисексуал, Bisexuality), (трансжендер, Transgender) буюу хүйсийн баримжааг илэрхийлсэн хүмүүс гэх ойлгуултуудыг ойлгодог, таниж мэддэг болжээ. Эдгээр нэр томъёог бэлгийн цөөнх хэмээн нэрлэгдэх нь олон боловч ЛГБТ нь илүү тохиромжтой хэллэг гэж дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн. Одоогоор энэхүү хэллэгийг өнцөг булан бүрт өргөнөөр ашиглаж байна. Өнөөгийн нийгэмд, ерөнхийдөө жендерийн үүргийн талаар бичих нь тодорхой ач холбогдолтой.

### **Зорилго**

Энэхүү өгүүлэлдээ Монгол улсад одоогоор жендэрийн үүрэг ямар байгааг судлах болно. Энэхүү сэдэв нь маш өргөн хүрээтэй бөгөөд дан ганц нэг өгүүлэлийн хүрээнд бүрэн судлах боломжгүй. Тус өгүүлэлдээ монголын өнөөгийн нийгэмд байгаа чухал, сонирхолтой, нэгэн зэрэг төвөгтэй сэдвийн зарим нийтлэг шинж чанарыг олж гаргахыг хичээсэн. Дэлхийн хамгийн том нутаг дэвсгэртэй хэрнээ цөөхөн хүн амтай энэхүү улсад жендэрийн боловсрол ямар байдгийг дараах байдлаар авч үзнэ.

Нэгдүгээрт, охид, хөвгүүдийн талаарх санаа бодол, үзэмж хэрхэн бий болдог; Хоёрдугаарт, хүйсийн тухай – эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ямар тодорхойлолтууд нийгэмд илүү давамгайл байдаг болон жендэрийн боловсролын талаар; Эцэст нь интернет дэх “коммент” буюу сэтгэгдэлд дүн шинжилгээ хийж, өнөөгийн монголын нийгэм дэх жендэрийн үүргийн талаархи ерөнхий санаатай харьцуулах болно. Өөрөөр хэлбэл, бидний судалгааны зорилго бол монгол улсад жендэрийн ямар ойлголт байгаа, мөн жендэрийн ямар үүрэг түлхүү байдаг, жендерийн ямар асуудлууд тулгарч байгаа болохыг өгүүлэх төдийгүй хүүхдийн хүмүүжилд ямар үүрэг гүйцэтгэдэг талаар тодорхой дурьдах болно. Нийгэм дэх жендэрийн үүрэг гэдэг нь бидний тогтоосон хүйсийн дагуу хэрхэн биеэ авч явах, ярих, хувцаслах, өөрт тогтоосон хүйсийн дагуу биеэ авч явах гэсэн үг. Жишээлбэл, охид, эмэгтэйчүүд ерөнхийдөө эмэгтэйлэг байдлаар хувцаслаж, эелдэг, найрсаг, халамжтай байх гэх мэт. Судалгааны асуулт:

1. Охид, хөвгүүдтэй холбоотой ямар үг хэллэг, яриа нийгэмд түлхүү ашиглагддаг вэ?

2. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүргийн талаар ямар санаанууд нийтлэг байдаг бэ?
3. Хүүхэд хүмүүжүүлэхэд хүйс ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?
4. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн жендэрийн үүрэг, жендэрийн боловсролын хооронд ямар хамаарал байна вэ?

Энэхүү өгүүлэлдээ Норман Фэрклоу-н онолыг ашиглах болно. Норман Фэрклоу бол Английн хэл шинжээч, англи хэлний профессор бөгөөд түүний судалгааны салбар нь хэл яриа, эрх мэдлийн салбарт ихээхэн нөлөө үзүүлсэн. Тэрээр шүүмжлэлтэй ярианы шинжилгээний (critical discourse analysis) анхдагч гэж үнэлэгддэг. Фэрклоу (1992) “Нийгэмд хэлний хэрэглээ нь хувь хүний үйл ажиллагаанаас илүү нийгмийн практикийн нэг хэлбэр юм” гэж үзсэн (Фэрклоу Норман, 1995). Түүний онолоор ярианд эрх мэдэл, үзэл суртал гарч байдаг гэж үзсэн.

Энэхүү онол нь бидний өгүүлэлд тохиромжтой гэж бид хувьдаа үзэж байгаа, учир нь бид жендэртэй холбоотой төрөл бүрийн яриаг судлах болно. Америкийн Физиологийн Нийгэмлэгийн (АФН) сэтгүүлд gender-хүйсийн нэр томъёо нь анх 1982 онд гарч ирсэн бол sex-секс нэр томъёог 1920-иод оны эхэн үеэс хэрэглэж эхэлсэн байна. 1990-ээд оны дунд үеэс л жендер гэдэг нэр томъёо нь АФН-ийн гарчиг дахь секс гэсэн нэр томъёог хэрэглээнээс гаргаж эхэлсэн байна. Аливаа улсад жендер, түүний үүрэг, хэрэгжүүлэх арга зам нь маш чухал. Жишээлбэл, хүйсийн тэгш бус байдлын индексээр Дани улс нь 2021 онд дэлхийн жендерийн тэгш эрхт улсаар тэргүүлжээ.

Хүйсийн тэгш бус байдлын индекс нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн амжилтын тэгш бус байдлыг нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх мэдэл, хөдөлмөрийн зах зээл гэсэн гурван хэмжүүрээр хэмждэг. Үүнээс өмнө эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бэлгийн үүргийн тухай асуудлыг нийгэм, гэр бүлийн үүднээс голчлон судалдаг байсан. Монголын гэр бүл дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг, нийгэмд эзлэх байр суурьтай холбоотой олон судалгаа бий. Бага насны хүүхдийн жендэрийн ач холбогдлын талаарх судалгаа ховор байна. Энэхүү өгүүлэлдээ бага насны жендэрийн талаархи зонхилох санааг судлахаар шийдсэн тул тус өгүүлэл нь онолын хувьд ач холбогдолтой.

### **Секс ба хүйс**

Тэгэхээр, “gender”, “sex” үгнүүдийн ялгаа юу вэ? Үндсэндээ “sex” буюу хүйс гэдэг нэр томъёо нь социологи эсвэл соёлын талыг илэрхийлдэг тул хүний биологийн хүйсийг илэрхийлэхэд ашигладаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бие махбод дахь биологийн тогтсон зүйл буюу цаг хугацаа өнгөрсөн ч өөрчлөгдөхгүй. Олон шинжлэх ухаанд биологи, хувьслын болон нийгэм-сэтгэл зүйн онолууд гэх мэт өргөн, өөр өөр үзэл баримтлалд суурилсан таамаглалыг харьцуулахын тулд байгалийн жам ёсны хүйс, хүйсийн ялгааг ашигладаг (Арчер, 2006; Миллер & Халперн, 2014; Вуд & Ийгли, 2002). Харин “жендер” гэдэг үг нь илүү орчин үеийн нэр томъёо. Нийгэм, соёлоос улбаатай, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох ялгаа. Тодорхой нэг нийгмийн зүгээс эрэгтэй, эмэгтэй хүмүүст зохистой хэмээн үзсэн үүрэг, зан төлөв, хандлага бөгөөд цаг хугацаа өнгөрөхийн хэрээр өөрчлөгддөг. Жишээлбэл, дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүйс, жендэрийн ялгааг дараах байдлаар нэгтгэн тодорхойлжээ. Үүнд: Хүйс гэдэг нь эр, эм хоёрын нөхөн үржихүй, хромосомын эрхтэн, гормон гэх мэт биологийн болон физиологийн ялгаатай шинж чанаруудыг хэлдэг. Жендер гэдэг нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нийгэмд бий болсон шинж чанарууд, тухайлбал, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн бүлгүүдийн хэм хэмжээ, үүрэг, харилцаа зэрэг гэсэн үг бөгөөд нийгмээс нийгэмд харилцан адилгүй өөр өөр байж болно.

Энэхүү хоёр нэр томъёо заримдаа андуурагддаг. Биологийн, танин мэдэхүйн, нийгэм, соёлын олон янзын хүчин зүйлүүд нэгэн зэрэг үйлчилдэг. Хүйс бол хүний амьдралыг зохион байгуулах хамгийн үндсэн арга замуудын нэг ч жендэрийн үзэл баримтлал нь олон талаас бүрддэг. Энэ дэлхий дээр хүний амьдралд хүйс, хүйсээс илүү нөлөөлж чадах өөр хүчтэй зүйл байхгүй байх. Хүйсийн нөлөөлөл нь төрсөн цагаас эхэлдэг, эсвэл бүр гэдсэнд бий болох үеэс ч эхэлдэг байж болох юм. Эцэг эхчүүд бид хүүхэдтэй болсон цагаас эхлэн хүүхдийнхээ хүйсийг урьдчилан мэдэхийг хүсдэг бөгөөд ингэснээр бид хүйсээр нь хувцас худалдаж авах, шинэ хүндээ нэр бодож олох гэх мэт зүйлст санаа тавьж эхэлдэг. Хэн нэгэн маань хүүхэд төрүүлэх үед хүмүүсийн хамгийн түрүүнд асуудаг асуултуудын нэг бол “ямар хүүхэд төрсөн бэ? хүү юу, охин уу?”.

Цаашилбал, биднийг өсөж, хөгжих үед хүйс бидний амьдралд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүйс нь биднийг ямар нэрээр дуудах, хэрхэн өсөж торних, хэрхэн ярих, бага насандаа тоглох тоглоом болон эдлэж хэрэглэх зүйлсд ямар нэгэн байдлаар нөлөөлдөг. Эмэгтэй, эрэгтэй хүний хүлээлт

(expectation) өөр байдгийг бид мэднэ. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөр өөр мэргэжилтэй (“эрэгтэй”, “эмэгтэй” ажил, мэргэжил), хүүхэд, гэр орноо хариуцах, хүмүүстэй харилцах харилцаа өөр өөр байж болно. Хүүхэд төрөх үед эцэг эхчүүд охид, хөвгүүдийг маш их ялгаатай гэж хэвшмэл байдлаар ойлгодог. Хүмүүс ерөнхийдөө охид, хөвгүүдийн ижил төстэй байдлаас илүүтэй ялгаатай байдлыг нь онцлох хандлагатай байдаг. Хэрэв бид энгийн зан үйлээс (хоол идэх гэх мэт) илүү төвөгтэй хэлбэрүүд (хэл ярианы хэрэглээ, танин мэдэхүйн нарийн төвөгтэй үйл явц гэх мэт) хүртэлх хүний зан үйлийн нөхцөл байдлыг бүхэлд нь авч үзвэл охид, хөвгүүд илүү төстэй гэж хэлж болно. Охид, хөвгүүдийн хооронд ямар нэг ялгаа байдаг болов уу? Хүүхдүүдийн жендэрийн үүргийн талаарх ойлголтыг ялгаж салгах нь зөв үү, эсвэл аль болох нэгдмэл ойлголттой байх нь зөв юм бол уу?

Жендэрийн үүргийг дараах байдлаар тодорхойлж болно: Нэг хүйстний онцлог, нөгөө хүйсийн хувьд ер бусын гэж үздэг зан үйлийн хэв маяг, хандлага, сонирхол. Энэ бол норматив шинж чанартай нийгмийн үүргүүдийн нэг төрөл бөгөөд тэдгээр нь бидний зан төлөвт илэрдэг нийгмийн тодорхой хүлээлтийг илэрхийлдэг. Хүйсээс хамаарч хувь хүмүүсийн үйл ажиллагаа, байдал, эрх, үүрэг ялгаатай байдаг, жишээлбэл хөдөлмөрийн хуваарилалт, эрх мэдэл, эрх мэдлийн хуваарилалт, нийгэм, хөдөлмөрийн талбар, гэр бүл, зан үйл, бэлгийн харьцааны хүлээлт зэрэг гээд бүх л нийгмийн сэдэвүүд ялгаатай байдаг. Эдгээр харилцаа нь үеэс үед өвлөгддөг.

Жендэрийн үүрэг гэдэг нь нийгмийн үүргийн нэг хэлбэр, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хүлээж буй зан үйлийн багц гэж ойлгогдог. Нийгмийн сэтгэл зүйд үүрэг гэдэг нь тухайн нийгмийн байр сууринд хүмүүс хэрхэн биеэ авч явах ёстойг тодорхойлсон хэм хэмжээний цогц гэж тодорхойлдог. Жендэрийн үүрэг, тэдгээрийн шинж чанар, гарал үүсэл, хөгжлийг нийгэм судлал, сэтгэл судлал, социологын онолын хүрээнд авч үздэг.

Соёлын хэмжүүрүүд нь шийдвэр гаргах үйл явцыг хөнгөвчлөхийн тулд тодорхой соёлыг үнэлэх үндэс суурь болдог бөгөөд хувийн чанар, гэр бүлийн түүх, хувийн сайн сайхан байдал зэрэг бусад хүчин зүйлсийг анхаарч үзэх хэрэгтэй гэдгийг Гирт Хофстеде онцолсон. Тэрээр үндэсний болон байгууллагын соёлын талаар анхдагч судалгаа хийдгээрээ алдартай. Хофстеде анхлан үндэсний соёл болон ажилтай холбоотой үнэт зүйлсийг тодорхойлох дөрвөн хэмжигдэхүүнийг тодорхойлсон: эрх мэдлийн зай, хувь хүн, тодорхойгүй байдлаас зайлсхийх, эрэгтэйлэг байдал. Түүний онолын дагуу хүйсийн үүргийн ялгаа нь тухайн соёлын эрэгтэй эсвэл эмэгтэйлэг байдлын түвшингээс хамаардаг. Хэвшмэл ойлголт бол нийгмийн үзэгдэл, объектын бүдүүвч, стандартчилсан дүрслэл бөгөөд ихэвчлэн сэтгэл хөдлөлийн хувьд өнгөлөг, тогтвортой байдаг. Хэвшмэл ойлголт нь бодит байдалтай алс холын харьцаатай байдаг. Хэвшмэл ойлголт нь объектив бодит байдлаас гадна үзэл суртал, домог, үнэт зүйлсийн үр дүнд бий болдог.

### ***Бэлгийн чиг баримжаа ба хүйс***

Psychoendocrinologist, хөгжлийн сексологийн чиглэлээр олон улсад алдартай доктор Жон Уильям Мони (1921–2006) жендэрийн үүрэг, өвөрмөц байдлын тухай ойлголтыг тодорхойлсон. Psychoneuroendocrinology нь дааврын төв ба захын мэдрэлийн системтэй динамик харилцан үйлчлэлцэж, зан үйлийн илрэл, эсийн үйл ажиллагаа, системийн түвшний үйл ажиллагаа, биеийн үйл явц, түүнчлэн тэдгээрийн эмнэлзүйн хэрэглээг судалдаг шинжлэх ухаан юм. Жон Уильям Мони 1973 онд жендэрийн гадаад бүрэлдэхүүн хэсгийн талаарх ойлголтыг дотоод бүрэлдэхүүн хэсгээс тусгаарласан. Илүү нарийн, гадаад бүрэлдэхүүн хэсэг нь жендэрийн үүрэг, дотоод бүрэлдэхүүн хэсэг нь хүйсийн баримжаа буюу бэлгийн чиг баримжааг тодорхойлдог гэж үзсэн. Хүйсийн баримжаа гэдэг нь “тухайн хүйсийн (эрэгтэй, эмэгтэй эсвэл өөр ангиллын хүн) өөрийгөө илэрхийлэх дотоод мэдрэмж юм” гэж тодорхойлжээ (Мони Жон, Анке Эрхардт, 1972). Тэрээр хүний хүйсийн баримжаа нь биологийн хүчин зүйл, хүмүүжил хоёрын харилцан үйлчлэлээр тодорхойлогддог гэжээ. Энэ нь жендэрийн баримжаа нь зөвхөн биологийн хүчин зүйлээс үүдэлтэй гэж үздэг өнгөрсөн үеийн сэтгэлгээг өөрчилсөн юм.

Жишээлбэл, heterosexuality (гетеросексуализм) гэдэг нь эсрэг хүйстэн эсвэл хүйсийн хүмүүсийн хоорондох романтик дур сонирхол, бэлгийн дур сонирхол эсвэл бэлгийн харилцаа юм. Бэлгийн чиг баримжааны хувьд гетеросексуализм нь эсрэг хүйсийн хүмүүсийн хувьд сэтгэл хөдлөлийн, романтик эсвэл бэлгийн дур хүслийн байнгын хэв маяг юм. Товчхондоо бол гетеро чиг баримжаа нь эсрэг хүйсийн хүмүүст чиглэсэн бэлгийн чиг юм. Статистик тоо баримтаар дэлхий дээр ихэнх хүмүүс, амьтад ийм бэлгийн чиг баримжаатай байдаг.

Homosexuality (гомосексуал) гэдэг нь ижил хүйстэн, хүйсийн гишүүдийн хооронд романтик дур сонирхол, бэлгийн дур сонирхол, бэлгийн харьцаанд орох явдал юм. Бэлгийн чиг баримжааны хувьд ижил хүйстнүүдийн хувьд ижил хүйстнүүдийн хувьд сэтгэл хөдлөлийн, романтик эсвэл бэлгийн дур хүслийн байнгын хэв маяг юм. Гомосексуал гэдэг нь гетеросексуал байдлаас ялгаатай нь ижил хүйсийн хүмүүст бэлгийн дур хүслийг татах явдал юм. Үүний талаарх санал бодол маш олон янз байдаг. Зарим нь үүнийг нүгэл гэж хэлдэг бол зарим нь өөр хувилбар гэж үздэг. Зарим онолчид эдгээр ялгааг биологийн шалтгаантай холбон тайлбарладаг боловч олон сэтгэл судлаачид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн зан үйлийн ялгаа нь биологийн үйл явцаас илүү нийгэмшлийн үр дүн гэж үздэг.

Хүний хүйсийг яагаад мэдэх ёстой, мөн яагаад жендэр бидэнд тийм чухал вэ гэсэн асуулт гарч ирнэ. Хэдийгээр олон нийгэмд зөвхөн гетеросексуализмыг норматив зан үйл гэж үздэг ч эрдэмтэд зарим соёлд **гуравдагч хүйс** байсаар ирсэн болохыг тогтоожээ. Ийм соёлууд жишээ болгон дурьдвал:

1. Албанийн соёл: Албани овгийн нийгэм эцгийн эрхт ёстой байв. Гэрлэлт үргэлж exogamy (экзогами) буюу омог хоорондын гэрлэлт байсан бөгөөд өрхийн тэргүүн шийдвэр гаргадаг байв. Хүүхдүүдийг заримдаа бүр төрөхөөсөө өмнө, ихэвчлэн өөр овогтой нөхөрлөл, энх тайвныг тогтоохын тулд сүй тавьдаг байв (п.а, 2015).

2. Америкийн индианчууд: Polygamy (полигами) гэдэг нь гурав ба түүнээс дээш хүний гэрлэлтийг илэрхийлдэг ерөнхий, хүйсээс хамааралгүй нэр томъёо юм. Polygyny (полиги) гэдэг нь нэг нөхөр, дор хаяж хоёр эхнэртэй гэрлэлтийг тодорхойлоход хэрэглэгддэг тусгай нэр томъёо юм. Энэ бол олон эхнэртэй болох хамгийн түгээмэл (мөн хамгийн түгээмэл хууль ёсны) хэлбэр юм. Олон эхнэртэй байх нь Guale (Гуале) болон Pueblo (Пуэбло)-гийн нийгэмд чухал ач холбогдолтой байсан. Эдгээр болон бусад олон уугуул Америкийн соёлд олон эхнэртэй байх нь бусад ойр орчмын бүлгүүд, мөн чинээлэг, өндөр статустай өрхүүдтэй удирдагчийн холбоог бий болгодог байжээ. Олзлолт нь олон эхнэртэй байх нийтлэг соёлын нэг хэсэг байсан бөгөөд өрсөлдөгч бүлгүүдийн эмэгтэйчүүд, хүүхдүүдийг гэр бүлд нэгтгэх боломжийг олгодог байсан (Ливиа Гершон, 2021). Тэдний дунд гуравдагч хүйсийн хүмүүс нийгэмд онцгой үүрэг гүйцэтгэдэг, тухайлбал, индианчууд маш их шүтлэгтэй.

3. Энэтхэгчүүдийн дунд гурав дахь хүйс нь сөрөг үзэгдэл гэж тооцогддоггүй байв. Энэтхэгийн хойгт hijra (хижра) гэдэг нь guru-chela (гуру-чела) систем гэж нэрлэгддэг ураг төрлийн тогтолцоог дагадаг нийгэмлэгт амьдардаг тайган, интерсекс хүмүүс эсвэл трансжендер хүмүүс юм. Agvani (аравани), aruvani (арувани), jogarra (жогарра) гэж нэрлэгддэг. Энэтхэгийн хижра нийгэмлэг нь дуу, бүжигт гарамгай домогт гардаг амьтдаар өөрсдийгөө “kinnaar” (киннар) гэж нэрлэхийг илүүд үздэг. Хижраг Энэтхэгийн хойгт гуравдагч хүйс гэж албан ёсоор хүлээн зөвшөөрдөг бөгөөд бүрэн эрэгтэй, эмэгтэй ч биш гэж үздэг. Хижрачууд нь Энэтхэгийн хайрын тухай өгүүлэх камасутраг гаргасан эртний түүхтэй (РүдКристофер, 2018).

Тэгэхээр жендэрт хувийн хүчин зүйл, улс төр, соёлын шийдвэр хүртэл нөлөөлдөг. Жишээлбэл, зар сурталчилгаа нь гетеронорматив байдлын талаархи ойлголтыг төрүүлж байдаг. Heteronormative (гетеронорматив) гэдэг нь гетеросексуал байх нь норм бөгөөд хүү эсвэл охин байх нь хэвийн үзэгдэл гэсэн үг юм.

### ***Боловсрол ба хүйс***

Боловсрол гэдэг нь хүүхдийг сургах, түүний хөгжлийг дэмжих, түүний зорилго нь түүний сайн сайхан байдлыг дэмжих явдал юм. Багш нь хүүхдийг олон янзын ертөнцтэй танилцахад дэмжиж тусалдаг. Эцэг эхийн хүмүүжлийг хөгжлийн сэтгэлзүйн үүднээс авч үзэж болно. Үүний тусламжтайгаар хүүхэд хэрхэн хэвийн хөгжиж байгаа, түүний хөгжилд ямар нэгэн асуудал байгаа эсэхийг харах боломжтой. Жишээлбэл, Финланд улсын хуульд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх тэгш байдлийн талаарх тухай нарийн дурьдсан байдаг. Тэгш байдал нь насанд хүрсэн үед биш, харин бага наснаасаа эхэлдэг. Тиймээс жендэрийн боловсрол ч гэсэн бага наснаасаа, бага насны боловсролоос эхлэх ёстой. Хүн бүрт боловсрол олгох ижил боломжийг олгох, сургалтын хөтөлбөрийг жендэрийн хэвшмэл ойлголтыг бий болгохгүй байх хэрэгтэй. Харамсалтай нь онол нь заримдаа практикаас ялгаатай байдаг бөгөөд бас тэгш бус байдаг.

Дэлхийн аль ч улсад жендэрийн төвийг сахих талаар анхаарал хандуулдаг. Энэ нь хүйсийн тэгш байдлыг хангах хамгийн сайн арга гэж ойлгогддог бололтой. Гэхдээ жендэрийн төвийг сахих байдал гэж юу вэ? Төвийг сахих - энэ нь жигд, ижил төстэй гэсэн үг юм. Ийм ойлголт нь хүйсийн ялгааг олж харахад илүү ярвигтай болгодог; Энэ нь хүйсийн хооронд ямар ч ялгаа байхгүй гэж ойлгоход хүргэдэг ч байж болох.

Харин жендэрийн мэдрэмж гэдэг нь ялгааг харгалзан үзэхийн зэрэгцээ хүн бүрт тэгш хандах чадвар (Анн Гордон, Жерри Л.Миллер, 2005). Гол нь жендэрийн утга учрыг арилгах, жендэрийг үл үзэгдэх болгох биш, харин хүүхдийг өөрөөрөө байх, өөрийнхөө хүссэн хүн болоход нь туслах, тэднийг жендэрийн явцуу дүрээр хязгаарлахгүй байх явдал юм. Товчхондоо, хүйсийн төвийг сахих нь ялгааг багасгадаг бол жендэрийн мэдрэмж нь үүнийг харгалзан үздэг. Жендэрийн мэдрэмж нь жендэрийг зөвхөн биологийн үүднээс бус соёл, нийгмийн тодорхойлолтоор нь судалдаг.

Хүйс нь өдөр тутмын амьдралд практик нөхцөл байдалд харагддаг. Ихэнхдээ энэ зан үйлийг уламжлалт зан заншилтай холбодог. Ийм зан заншлыг байгалийн жам ёсны гэж үздэг. Хүүхдүүд нэг бол гэртээ эцэг эх, ах эгч, дүү нарын хамт мөн сургууль, цэцэрлэг, асрамжийн газар сурган хүмүүжүүлэгчидтэй өсөж, нийгэмшдэг. Сурган хүмүүжүүлэгчид жендэрийн боловсролд төдий л анхаарал хандуулдаггүй, мөн эцэг эх ч хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэх талаар өнгөцхөн бодох юм бол юу ч өөрчлөгдөхгүй. Сурган хүмүүжүүлэгчийн ажил амаргүй, учир нь тэдэнд олон үзэл бодол, үнэт зүйлс нөлөөлдөг. Ихэвчлэн эцэг эх, сурган хүмүүжүүлэгч, бидний хүмүүжил охид, хөвгүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг идеал хувилбарт хүргэхийг хичээдэг явдал. Хэрэв эцэг эх, сурган хүмүүжүүлэгчид маань жендэрийн тэгш байдлын дагуу хичээдэг бол жендэр нь олон ойлголт, хүмүүжилд хөгжил болох боломжтой юм.

Хоёр хүйстэнд боловсрол эзэмших тэгш боломжийг олгохыг “боловсролын тэгш байдал” гэж нэрлэдэг. Хэрэв сурган хүмүүжүүлэгч эсвэл хүүхдийн эцэг эх нь хүйс харгалзахгүйгээр хүүхэдтэй харьцах, өөр өөр сонирхолтой хүн байдаг гэж ойлгож хүүхэдтэйгээ харьцах юм бол “ёс суртахууны өсөлтийг” хамгийн сайн дэмжиж чадна. Мөн үүнээс өөр өөр үзэл бодолтой хүмүүсийг хүндлэх ёстойг хүүхэд олж суралцах болно. Үеэс үед сургууль дотор эсвэл сургуулиас гадуурх дээрэлхэлтыг багасгахын тулд хүүхдүүд бие биенийгээ ойлгож, хүн бүр адилгүй, ялгаа зүйлс байдлыг сургаж, ойлгуулах гэж хичээж байгаа.

Бяцхан хүүхэд өөрийн хүйсээ хараахан мэддэггүй, хүйсийн ялгааг ойлгоогүй байдаг. Энэ нь хүүхдийн хүмүүжсэн орчин, нийгэмшил, соёлоос ихээхэн хамаардаг. Хүүхэд гурван наснаас эхлэн хүйсийн ялгааг ойлгож эхэлдэг байна. Зөвхөн сурган хүмүүжүүлэгчид ч биш, бүх хүмүүс охид, хөвгүүдийн тухай ярьдаг. Тиймээс энэ талбарын тухай ойлголт бий болдог, энэ нь хүү эсвэл охин, эмэгтэй эсвэл эрэгтэй байх ямар байдгийг хүмүүс бид өөрсдөө л тодорхойлдог. Өдөр тутмын амьдралын хэв маяг, харилцаа бүр энэ ойлголтыг бий болгодог. Хүүхдийн хувцас, тоглоом, өрөөний чимэглэл, ном, дуу хөгжим гээд бүх л зүйлсийг хүйсээр сонгодог. Гэхдээ бүх хөвгүүд адилхан байдаггүйтэй адилхан охид бүр өвөрмөц байдаг. Хүүхдүүдийг зөвхөн хэвшмэл охид, хөвгүүд биш харин өөр өөр хөвгүүд, өөр өөр охид байдаг гэж ойлгож эсвэл ойлгуулах нь зүйтэй.

Хамгий чухал нь хүүхдийг өөрийн хүслээс өөр зүйл хийхийг албадахгүй байх явдал юм. Эцэг, эх, сурган хүмүүжүүлэгч бид нар тэдэнд өөрсдөө шийдвэр гаргах боломжийг олгох хэрэгтэй. Жишээлбэл, цэцэрлэгт охид, хөвгүүдэд хүүхэдтэй, машин тоглох боломжийг олгох хэрэгтэй. Хэрэв охин үргэлж машинаар тоглохыг хүсдэг бол түүнийг хүүхэдтэйгээр солихыг албадах ёсгүй. Хамгийн гол нь хүүхдүүд хэвшмэл ойлголтоор хязгаарлагдахгүй, харин өөрсдийн хүслийн дагуу шийдвэр гаргах боломжтой байх нь зүйн хэрэг.

Бид хүйсийн ялгааг сул тал гэж үзэхгүй, харин бие биенээ нөхөж чадах ялгаа гэж ойлгох хэрэгтэй. Эмэгтэйчүүд эрчүүдээс илүү мэдрэмтгий байдаг, гэхдээ энэ нь сул тал биш, харин хүний шинж чанар юм. Эмэгтэй хүн заавал эрчүүдтэй адилхан болох албагүй, мөн эсрэгээрээ ч байх албагүй. Эмэгтэй, эрэгтэй хүмүүст хүний ерөнхий шинж чанарууд гэж байдаг. Жишээлбэл, зарим эмэгтэйчүүд эрчүүд шинж чанар давуу байдаг бол зарим эрчүүдэд эмэгтэй шинж чанар илүү давамгайл байдаг. Мэдээжийн хэрэг, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү хүчтэй, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү зөөлөн, илүү халамжтай байдаг. Энэ бүхэнд соёл, хүрээлэн буй орчин, гэр бүл, нийгэмшил нөлөөлдөг. Мөн орчин хэр их нөлөөлдөгийн хариултыг олох нь тийм ч амар зүйл биш юм. “Nature versus Nurture” гэсэн хэллэг нь хүний шинж чанарыг “nature” (байгаль) эсвэл “nurture” (хүмүүжил) аль нь илүү чухал үүрэг гүйцэтгэдэг вэ гэсэн асуултын хариултыг олоход тус болсон.

“Байгаль” гэдэг нь төрөлхийн биологийн хүчин зүйл (жишээ нь генетик) гэсэн утгатай бол “хүмүүжил” гэдэг нь хүмүүжил, хүрээлэн буй орчин, амьдралын туршлагыг ерөнхийд нь хэлж болно. “Байгаль” буюу төрөлхийн хүчин зүйлс нь ихэвчлэн удамшлын болон дааварт суурилсан зан үйл, зан чанар, гэж тодорхойлдог бол хүмүүжлийг хүрээлэн буй орчин, соёл, туршлага гэж тодорхойлдог.

Биологи, өөрөөр хэлбэл хүний хүйс нь хүрээлэн буй ертөнцөөс үл хамааран тухайн хүн өөрөө үүрэг гүйцэтгэж, хариу үлдэл гаргадаг. Өөрөөр хэлбэл, дан ганц биологи, эсвэл зөвхөн нийгмийн орчин л үүрэг гүйцэтгэж хариу үйлдэл гаргадгүй. Гэхдээ жендэрийн мэдрэмжийн эерэг тал нь охидыг цагдаа, инженер, эсвэл эрэгтэйчүүдийг тогооч, багш мэргэжлээр ажиллахыг хязгаарладаггүй явдал юм. Зарим олон улсын судалгаанаас харахад хүүхэдтэйгээ ганцаараа амьдардаг аавууд өрх толгойлсон эхчүүдээс дутахгүй гэр орон, хүүхдээ асарч чаддаг тоо баримт ч цөөнгүй байна. Гэвч өнөө үед эмэгтэйчүүд ажил амьдралд урьд өмнөхөөсөө илүү оролцож, эрэгтэйчүүд гэрийн ажил хийх хандлагатай байгаа хэдий ч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүргийн талаарх уламжлалт үзэл бодол тогтвортой хэвээр байна. Ихэнх хүмүүс эрэгтэй хүн гэр бүлээ тэжээгч буюу олон улсын хэллэгээр “bread winner” гэж нэрлэгддэг. Bread winner (гэр бүлээ тэжээгч) бол гэр бүлийн хэрэгцээт мөнгийг олдог гэр бүлийн гишүүн бөгөөд гэр бүлийн тэжээгч нь ихэвчлэн эрчүүд байдаг бөгөөд тэдний үүрэг нь мөнгө олох. Нөгөө талаас, “Homemaker” (гэрийн эзэгтэй) нэр томъёо нь эмэгтэйчүүдтэй холбоотой үг хэллэг бөгөөд бүтэн цагийн гэрийн эзэгтэй гэсэн утгаар 19-р зууны дунд үеэс АНУ-д гарч ирсэн нэр томъёо. Харин эмэгтэй хүн гэр орноо хариуцах ёстой гэдэг үзэл бодол, хадлага, харьцаа өдгөө болтол аль ч нийгэм, соёл, улсад нийтлэг хэвээр байна.

### ***Судалгааны арга зүй***

Энэхүү өгүүлэлдээ чанарын судалгааны аргыг ашигласан. Чанарын судалгааны аргын зорилго нь тухайн үзэгдлийг дүрслэх явдал юм. Мөн дискурсын шинжилгээ нь чанарын судалгаа юм. Дискурс гэдэг нь тухайн нийгэм-соёлын уламжлалд давамгайлсан оновчтой төрлөөр зохицуулагддаг хүний ухамсрын агуулгыг объектчлэх, үгээр илэрхийлэх. Чанарын судалгааны хандлага нь хүний зан төлөвийг судалж, бие биетэйгээ харилцахдаа хүмүүс өөрсдөө бий болгосон тайлбар, түүний утгыг судалдаг. Судалгааны объект нь хүний утгын ертөнц бөгөөд өөр өөр үнэт зүйлс дээр суурилсан ертөнц. Дэлхий дээр амьдарч буй хүн янз бүрийн үйл явдал, үзэгдлийн утга учрыг тайлж, ойлгох ёстой. Утга нь өдөр тутмын амьдралын харилцаа, үг хэллэгээр бий болдог – энэ нь нийгмийн конструктивизмээс авсан онол. Түүнчлэн, энэ аргын хувьд тэдгээрийн утгыг агуулгын хүрээнд ойлгох нь чухал юм.

Социологи бол хувь хүний зан үйлийн нийгмийн нөхцөл байдлын тухай юм. Жишээлбэл, Маркс, Дюркгейм нарын сонгодог социологи нь коллективист арга зүйд суурилдаг. Нэгдэлчлэлийн соёл (collectivist culture) нь хувь хүн бүрийн хэрэгцээ, хүслээс илүүтэйгээр бүлгийн хэрэгцээ, зорилгыг онцолдог. Ийм соёлд бүлгийн бусад гишүүдтэй харилцах харилцаа, хүмүүсийн хоорондын харилцан уялдаа холбоо нь хүн бүрийн өвөрмөц байдалд гол үүрэг гүйцэтгэдэг. Микро социологи 1930-аад онд гарч ирсэн. Энэ нь хувь хүн нийгмийн амьтан байх ёстой гэсэн индивидуалист арга зүйд суурилдаг. Гэр бүл, хөдөлмөрийн байгууллага гэх мэт харьцангуй жижиг бүлгүүдэд байнгын харилцан үйлчлэл нь соёлыг төлөвшүүлэхэд хүргэдэг. Соёлын тухай социологийн санаа нь түүний өдөр тутмын амьдралын утга учраас ялгаатай нь бүлэг хүмүүсийн амьдралыг хэрхэн тайлбарлаж, ойлгоход хамаатай. Тэдний ертөнцийн зураглал нь тэдний үнэт зүйл, зан үйлийн хэм хэмжээг өгдөг.

Хэлний хэрэглээ нь нөхцөл байдал, цаг хугацаа, байршил, зорилгоос хамааран харилцан адилгүй байдаг. Тиймээс яриа нь динамик шинжтэй, яриа болон бусад нөөцийг ашиглах нь ярианы объект, нөхцөл байдалд нөлөөлдөг. Энэ нь сонсогч, илтгэгчийн хоорондын харилцаанд ч нөлөөлдөг. Хэл яриаг судлахад микро ба макро түвшин нь институци, төрийн болон нийгмийн нөхцөл байдалтай холбоотой. Энэ холбоо нь яриа, төрөл, өгүүлэмж гэсэн ойлголтууд юм. Яриа нь дүрслэх, хязгаарлах, өөрчлөх, ангилах, тодорхойлох, шалгах, мэдрэмжээ илэрхийлэх, ярилцах дикурсив (discursive) чадвартай байдаг.

Хүрээлэн буй ертөнцийг яриа хэлцлээр байгуулах нь бүтээн байгуулалт юм. Яриа ашиглахдаа хүн өөрийнхөө тухай, бидний тухай, бусдын тухай, өнөөгийн цаг үе, соёлын бүтэц, нийгмийн уламжлалын тухай ярьдаг. Тиймээс ярианы соёлын нөхцөл нь чухал: бид харицан яриа өрнүүлж, хоорондоо ярилцаж, түүнээсээ суралцдаг, энэ бүхэн соёл, яриатай холбоотой байдаг.

Харин баримтлал гэдэг нь өөрийнхөө тухай, “би” гэж юу болох тухай ойлголт юм. Ийм ойлголт нь субъектив туршлага, өөрийн тухай ойлголт, нийгмийн нөхцөл дэх ярианы тусламжтайгаар бий болсон ойлголт юм. Мөн бүлгийн өвөрмөц байдал - бидний тухай ойлголт нь хэлний тусламжтайгаар бий болдог. Энэ үйл явцад түүх, хэвлэл мэдээлэл, зар сурталчилгаа гэх мэт зүйлс нөлөөлдөг. Яриа нь танин мэдэхүйн орчуулагч юм.

Хэлний үүрэг нь хэлний утгыг агуулгаар нь тайлбарлаж, тэдгээр нь харилцааны хэлбэрээр хэрхэн бүтээгдсэнийг тайлбарладаг. Холлидей-н хэлснээр хэлний хэрэглээнд дараах гурван үүрэг байдаг: текстийн үүрэг, дүрслэх үүрэг, харилцааны үүрэг (М.Холлидей, 1973). Энэ нь тухайн хүн ямар хэлний эх сурвалж, хэрхэн ашиглахаа мэддэг эсэхээс хамаарна. Яриа нь олон янзын талыг агуулдаг. Ярилцлагыг судлах материал нь голчлон аман болон бичгийн, мөн дохионы хэл гэх мэт харааны систем болон бусад системүүд, текст болон олон төрлийн материалууд ашиглаж болно.

Хэлний дискурсив хэрэглээнд яриа, өгүүлэмж орно. Харилцааны түвшинд эрх мэдлийн талаархи төлөөлөл, өвөрмөц байдал, асуултууд байдаг. Жишээлбэл, харилцааны түвшинд төрийн бүтэц эсвэл түүхэн нөхцөл байдал байдаг. Харин боловсрол, хүйс, хүүхэд нас нь харилцааны түвшинд хамаарна. Дискурсив төлөвт микро болон макро түвшин нэгэн зэрэг гарч ирэх ба тэдгээрт зарим түвшин байх ба тэдгээрийн хооронд шилжих боломжтой. Заримдаа ярианы хэрэглээнд нийгэм, институцийн хэм хэмжээ, дүрэм журам, бичмэл бус дүрмүүд нөлөөлж болно. Мөн шийдвэр, үнэт зүйл нь ярианы хэрэглээнд нөлөөлж болно. Энэ үйл явцад байршил, дадал зуршил, соёл ерөнхийдөө чухал үүрэг гүйцэтгэдэг. Дээр дурдсан зүйлсийн үндсэн дээр хүн нэг бүр үг хэллэг ашигладаг хүмүүсийн тухай болон хүрээлэн буй нийгмийн талаархи өөрсдийн санаа бодлыг байнга бий болгодог.

Яриа судлалын бүх судалгаанд тохирох ганц, хоёр арга гэж байдаггүй. Дискурсив шинжилгээний зорилго нь яг нэг “зөв” ойлголтыг олох оролдлого биш харин судалгааны үр дүн, хэлний хэрэглээний микро түвшнийг макро түвшний өргөн хүрээтэй, харилцааны үйл ажиллагаатай холбохын тулд нэгээс олон аргыг ашиглах шаардлагатай. Гэсэн хэдий ч ярианы судалгаа нь нийгмийн конструктивизмын онол дээр тулгуурладаг.

### ***Норман Фэрклоу’s critical discourse analysis буюу шүүмжлэлтэй ярианы дүн шинжилгээ***

Энэхүү өгүүлэлдээ Норман Фэрклоу -ийн гурван хэмжээст загварын шүүмжлэлтэй ярианы дүн шинжилгээг (critical discourse analysis) ашиглах болно. Тус загварт текст өөрөө, ярианы практик, нийгмийн практик гэсэн гурван түвшинг багтаасан болно. Тухайн загварын зорилго нь ярианы дүн шинжилгээ хийх аналитик хүрээ байна.

Хэрэглээний хэл шинжлэлийн эрдэмтэн Норман Фэрклоу текст болон тэдгээрийн нийгмийн зорилгын хоорондох холбоог тогтоохын тулд “яриа хөөрөө” (discourse) гэсэн нэр томъёог ашигладаг. Олон янзын онолын байр сууринаас томъёолсон зөрчилдөөнтэй, давхцсан тодорхойлолтууд байдаг тул яриа нь ярвигтай ойлголт юм. Норман Фэрклоу харилцааны явцад хэлний хэрэглээ бүр нь текст тайлбарлах үе шат (text description stage), ярианы практик/яриа тайлбарлах үе шат (discursive practice/discourse interpretation stage) болон нийгмийн практик/нийгэм соёлын элементүүд тайлбарлах үе шат (social practice/socio-cultural elements explanation stage) гэсэн гурван хэмжигдэхүүнд хуваасан. Түүгээр ч зогсохгүй тэрээр нийгэм соёлын практикт янз бүрийн үе шатуудад яриа хэлцлийг хэд хэдэн түвшинд буюу хувь хүний түвшинд, институцийн түвшинд, нийгмийн түвшинд ангилсан (Фэрклоу Норман, 1995).

Энэхүү өгүүлэлдээ гурван хэмжээст **Фэрклоу-н** загварыг ашиглан гурван түвшингээр аман бус, бичгийн хэлийг судлахыг хичээлээ. Тиймээс бид энэ ажилдаа шүүмжлэлтэй ярианы дүн шинжилгээний тусламжтайгаар монгол хэл дээрх хүйсийн талаар нийгэм ямар ойлголттой байгааг судлахыг зорилоо. Нэг харилцааны үйл явдалд янз бүрийн төрөл, яриа хамтдаа гарч ирэхэд ярианы дараалал, харилцан яриа мөн үүсдэг. Interdiscursivity бол текст хоорондын харилцааны нэг хэлбэр юм. Текст хоорондын харилцааны тухай ойлголтыг ашиглан харилцааны үйл явдлууд нь үргэлж өнгөрсөн үйл явдлууд дээр тулгуурладаг: текстүүд нь өмнөх бичвэрүүд дээр суурилдаг. Жишээлбэл, текст өөр текстийг иш татсан байж болно, илтгэл нь аман болон бичгийн яриаг холбож байж болно, шинэ текст бүтээхдээ бусад бичвэрийн элементүүдийг багтаасан байж болно гэх мэт. Ихэнхдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэлд олон төрлийн элементүүдийг ашигладаг.

## **Судалгааны материал**

Бидний судалгааны материал нь **google** хайлтын системээр дамжуулан интернетээс олж авсан монгол хэл дээрх нээлттэй сайтууд дээрх бичвэрүүд юм. Сэтгэл зүйчдийн үзэл бодлыг бид сонирхож байгаа бөгөөд, учир нь тэд хувь хүний сэтгэцийн үзэгдлийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд бөгөөд тэдний зорилго нь хүмүүст туслах явдал бөгөөд ингэснээр тэд ямар боловсрол нь хүүхдийн сайн сайхан байдалд хүргэдэг болохыг судлаж бусдад түгээж, тусладаг. Тиймээс бид сэтгэл судлаачдын санал бичсэн сайтууд дээр ажиглалт хийж ажилсан. Тиймээс бид сэтгэл судлаачдын бичсэн, эсвэл сэтгэл судлаач, сэтгэл судлалын тэнхимийн вэбсайтад бичсэн, эсвэл сэтгэл судлаачийн дүгнэлтийг бичсэн текстийг судалгааны гол сууриа болгосон. Мэдээж сэтгэл судлаач бүр өөр өөр үзэл бодолтой байж болох ч тэд судалгаандаа ерөнхий онол, сэтгэлзүйн аргуудыг ашигладаг гэж бид үзэж байна.

Энэ ажлын зорилго нь “яаж” эсвэл “хэрхэн” гэсэн асуултын хариултыг олох биш харин хүүхдийг хэрхэн өсгөж хүмүүжүүлэх, охид, хөвгүүдийн хүмүүжилд хүйсийн ямар үүрэг чухал болохыг судлахаар зорьсон. Өөрөөр хэлбэл “тэд хэн болох ёстой вэ” буюу илүү нарийн асуултын хариултыг олох юм. Тиймээс бид боловсролын зорилго, боловсролд юуг анхаарахыг санал болгож, тэд ямар шинж чанар, зан чанарыг боловсролоор авч, сурахыг хүсч байгааг судалж байна. Ихэвчлэн охид, хөвгүүдийг өөр өөр нэр томъёогоор тодорхойлдог. Ямар зан араншин нь охинд, аль нь хөвгүүнд тохирсон байх нь соёлоос шалтгаална.

## **Охидыг тодорхойлж буй “төгс” шинж чанарууд**

Охидын онцлог шинж чанаруудын талаар ярихдаа хүн бүр “сайн охин”-ыг хамгийн тохиромжтой дүр гэж үзэх бөгөөд сайн охин болгож түүнийг өсгөн хүмүүжүүлэх нь гол зорилго юм. Бид хүмүүжлийн үр дүнд олж харахыг хүсч буй охидыг хүмүүжүүлэх үзэл санааг текстээс хайсан юм. Дараах жишээнүүдээс бид охидын төгс буюу “idol” шинж чанарын тухай олж мэдэх болно. Уламжлалт үзэл бодлын дагуу гэрийн эзэгтэйн үүрэг нь эмэгтэй хүйст нийгэм, соёлд хамаардаг. Монгол эмэгтэй хүний хувьд тэд гэр орноо арчлах ёстой. Насанд хүрсэн үедээ энэ дүрийг төгс эзэмшихийн тулд үүнийг багаасаа сурахаас өөр арга зам байхгүй мэт охидыг зааж сургаж, чиглүүлдэг. Нийгэм тэднийг эмэгтэй хүн ажиллах нь чухал гэж ойлгуулдаггүй, харин гэрийн сайн эзэгтэй байх нь чухал гэж ойлгуулдаг.

(1) “...юуны өмнө бяцхан хатагтай ирээдүйд гэрийн эзэгтэйн үүргийг төгс даван туулах ёстой. Тиймээс нялх хүүхдэд багаас нь цэвэрлэх, оёх, хоол хийх, аяга таваг угаах ур чадварыг эзэмшүүлэхийг хичээх хэрэгтэй” (Сайт 2о). (2) “... ирээдүйн эмэгтэй гэр орон болон өөрийгөө халамжлах чадвартай байх ёстой; өөрөөр хэлбэл хэмнэлттэй байж, цэвэр ариун байдлыг хайрла”(Сайт 2о). (3) “Охидыг хангалттай хэмжээнд гэрийн ажилд оролцуулж байх нь зүйтэй. ....охиндоо гадаад төрхөөс гадна өрөөгөө цэвэр байлгахыг зааж өг”. (Сайт 3о)

Зарим жишээнд охин хүүхэд нь бие даасан, янз бүрийн үйл ажиллагаа явуулах чадвартай байх нь чухал гэж үздэг тал ч ажиглагдсан бөгөөд алх хадаас, сүх зэрэг хөдөлмөрийн багаж зэвсэгтэй ажиллаж сурсан байх талаар ч бичвэр олдсон. Энэ бичвэр нь охины хүмүүжилд аавын үүрэг чухал болохыг мөн дурдсан байдаг, учир нь эцэг эх нь охиндоо өөр өөр чадваруудыг заах ёстой гэж дурьдсан байдаг. (4) “Хүүхдээ багаас нь хөдөлмөрлөж сурга. ....ээжүүд: гэрээ цэвэрлэх, оройн хоол хийх, оёх, нэхэх зэргийг заана. ....аавууд: хадаас алх, хушига хаглах, хөл бөмбөг тоглох, дугуй унах, цанаар гулгах, тэшүүрээр гулгах зэргийг заах нь зүйтэй. ....ийм тоглоомд бага ч гэсэн ур чадвартай байх нь охиныг цогцоор нь хөгжүүлнэ” (Сайт 1о).

Бидний мэдэж байгаачлан эцэг, эхчүүд охиныхоо гадаад төрхөнд онцгой анхаарал хандуулдаг бөгөөд тэднийг үзэсгэлэнтэй, эмэгтэйлэг хувцаслах нь зүйтэй гэж үздэг. Эмэгтэйчүүд нүүрээ будаж, өөртөө анхаарал тавьдаг байх ёстой гэж үздэг, өөрөөр хэлбэл нүүр будалт нь эмэгтэйчүүдийн хувьд байгалийн байх ёстой зүйл гэж тооцогддог. Ийм эмэгтэйлэг зан чанарыг мэдээж ээж нь зайх ёстой. (5) “Охин чинь анх удаа хөвгүүнтэй болзоонд явах гэж байгаа бол сайхан даашинз сонгох, нүүр будалт хийхэд нь ээж нь түүнд зааж өгөх нь зүйтэй” (Сайт 2о).

Дараах жишээнээс бид охидод хамааруулж ойлгодог арвиг хямгач, даруу зан зэрэг олон уламжлалт зан чанарыг олж харах болно. Түүнд авьяас чадвараа хөгжүүлэх боломжийг олгох нь чухал чадварууд. (6) “Мэдээжийн хэрэг, охины хувьд чухал чанаруудын нэг бол тусч зан чанар, гэрийн ажил хийх, даруу байдал, гэхдээ үүний зэрэгцээ амьдралын идэвхтэй байх ёстой. Та охиндоо

өөрөөс нь харахыг хүсч буй чанаруудынхаа жагсаалтыг гаргаж өгөх нь зүйтэй байх, гэхдээ гол нь хүүхдээ сонсож, түүний авьяас, эерэг хандлагыг нь олж илрүүлж, хөгжүүлээрэй” (Сайт 3о).

Дараах жишээг бид эмэгтэйчүүдийн аз жаргал гоо үзэсгэлэнд нь байдаг гэж ойлгож болно. Өөртөө итгэх итгэлийг бий болгоход гадаад төрх, гоо сайхан чухал үүрэг гүйцэтгэдэг гэдэгт бид итгэдэг ч энэ нь төдий л үнэн зүйл биш. Гэхдээ эмэгтэйчүүдийн ертөнцөд энэхүү ойлголт, хандлага үргэлж байдаг. Иймээс гадаад гоо үзэсгэлэн чухал, ялангуяа манай улсад эмэгтэйчүүдийг өв тэгш царайтай байхыг илүүд үзэх хандлага улам нийтлэг болж байна. (7) “Охиныг аз жаргалтай байлгахын тулд хэрхэн өсгөх үндсэн зарчмуудын нэг бол гоо үзэсгэлэнг мэдрүүлэх явдал юм. ...ээж нь хүүхдэдээ үлгэр дуурайл болж, (мөн) түүний үлгэр дуурайллыг бий болгоход анхаарах ёстой. Түүний хэв маяг, цэвэр цэмцгэр байдал, гадаад төрх байдалд анхаарал тавих. Охиноо хүмүүжүүлэх энэхүү үндсэн зарчим нь нэн чухал, учир нь хэрэв охин чинь өөрийгөө бусдаас дорд үзэх мэдрэмжтэй өсөх юм бол тэрээр амьдралынхаа туршид сул дорой, хүчгүй байдлаа мэдэрч түүндээ шанлаж амьдрах болно” (Сайт 2о). (8) “Хүүхдүүд бага насандаа тоглодог байсан тоглоомныхоо дүрсийг өөрийгөө гэж ойлгож санадаг байж болох тул эцэг эхүүд охиндоо хүүхэлдэй сонгож өгөхдөө хөөрхөн, зөв дүр төрхтэй, түүнд тохирсон хүүхэлдэйг сонгох хэрэгтэй” (Сайт 3о).

Охин хүүхэд бол охин шиг л байх ёстой гэж томчууд бид шууд хэлдэг. Тиймээс тэр бүх эмэгтэйд талыг бий болгох хэрэгтэй; зөөлөн, эелдэг, эмэгтэйд, энэрэнгүй, халамжтай байх. Энэ нь илүү уламжлалт хэвшмэл ойлголт. (9) “...жинхэнэ охиныг хүмүүжүүлэх үндсэн зарчим бол эмэгтэйд чанарыг төлөвшүүлэх явдал юм. Ирээдүйн эмэгтэй хүн бүр эелдэг зөөлөн байх ёстой. ...охиныг хүмүүжилд эмэгтэйд байдал, энэрэнгүй сэтгэл, энхрийлэл, халамж зэрэг ямар ч эмэгтэйд зайлшгүй шаардлагатай чанаруудад байх хэрэгтэй” (Сайт 2о).

Дараах жишээнээс харахад зарим сонирхолтой зүйлс гарч ирж байна: нэгдүгээрт, орчин үед “төгс гоо сайхны тухай” зарим бодит бус үзэл баримтлалыг харуулж байна, хоёрдугаарт, тэд гадаад төрх нь сөрөг хандлага, амьдралын таашаалыг бууруулж байна, гуравдугаарт, өөрийгөө болон өөртөө итгэх итгэл нь амьдралын баяр баясгалан эмэгтэйчүүдийн амьдралын хамгийн чухал зүйл гэж тэд бичжээ. Өөрөөр хэлбэл, энд тэд эмэгтэй хүний дотоод үнэлгээг амьдралынхаа хамгийн чухал зүйл гэж үздэг. Энэ талыг илүү орчин үеийн гэж үзэж болно. (10) “Өнөөдөр нийгэмд бие бялдрын хувьд төгс байх шаардлага утгагүй байдалд хүрчээ: “хамгийн төгс” эмэгтэйчүүд ч биднийг сэтгүүлийн хуудаснаас, телевизийн дэлгэцээс, олон нийтийн соёлын нөлөөгөөр хардаг, үнэлдэг бас дагадаг (follow). Бага болон өсвөр насны хүүхдүүдэд маш хүндээр тусдаг тэд илүүдэл жинтэй эсэх, хэн нэгэн үеийн хөвгүүндээ таалагддаг эсэхдээ шаналдаг. Өөрийнхөө гадаад төрх байдалд сөрөг хандах нь эмэгтэйчүүдийн амьдралыг ихээхэн хязгаарлаж, баяр баясгаланг нь хасдаг. Охид, эмэгтэйчүүд минь бусдын үзэл бодол, хөндлөнгийн үнэлгээ чухал биш, харин бид өөртэйгөө хэрхэн харьцаж байгаа, юу хүсч байгаа нь л чухал юм шүү.” (Сайт 2о)

Өнөөдөр “ямар нэгэн төгс” охиныг өсгөх гэж хичээх нь үнэ цэнэтэй байхаа болжээ, өөрөөр хэлбэл одоо цаг үе өмнөхөөсөө өөр болсон гэсэн үг юм. (11) Өнөөдөр та ямар нэгэн “хамгийн тохиромжтой” охиныг өсгөхийг хичээх ёсгүй, түүнд ямар чанарууд байдгийг урьдчилан танисан байх хэрэгтэй: эцэст нь гэр бүл бүрт хүүхэд өсдөг – тэд өөрийн онцлог шинж чанар, даруу байдал, хүсэл сонирхол, авьяас чадвартай болон төгс бус байдалтай. Мэдээжийн хэрэг, энэ нь хүйс харгалзахгүйгээр бүх хүүхдэд бүрэн хамаатай” (Сайт 1о). (12) “Бид охидод жендэрийн хэвшмэл ойлголтыг тулгах ёсгүй, жишээлбэл: “Хөвгүүд математик, нарийн шинжлэх ухааныг илүү сайн ойлгодог” гэх үзлийн оронд “охид математикт амжилтанд хүрч чадна” гэж хэлэх нь зүйтэй болов уу” (Сайт 2о)

Монгол улсад охидыг хөвгүүдээс ялгаатай хувцаслах нь чухал юм. (13) “Хүүхэд насандаа хүйсийг ангилж, ялгах нь ихэвчлэн хувцас хунар байдаг өнөө цагт цэцэрлэгт “юнисекс” загвар гэж нэрлэгддэг хувцасыг эцэг, эхчүүд түлхүү сонгох болжээ.” (Сайт 2о)

### ***Хөвгүүдийг тодорхойлж буй “төгс” шинж чанарууд***

Монголын нийгэмд эрэгтэй хүүхэд байхын тулд ямар зан чанарыг олж харахыг зорилоо. Охиныг хүмүүжилтэй харьцуулахад эрэгтэй хүүхдийн хүмүүжил асуудалтай гэж үздэг. Гэсэн хэдий ч хөвгүүдийг өсгөх зорилго бол тодорхой: бид ирээдүйд хөвгүүдээ зүй зохистой, өөртөө итгэлтэй, зорилготой хүн болгон хүмүүжүүлэхийг хүсдэг. Дараах жишээнүүдээс хөвгүүдийн тухай авч үзвэл:

(1) “эцэг эхчүүд ялангуяа хөвгүүдийг хүмүүжүүлэхэд асуудалтай тулгардаг. Эцэг эх бүр хүүгээ үнэ цэнэтэй, өөртөө итгэлтэй, зорилготой хүн болгон өсгөхийг хүсдэг” гэж хэлжээ. (Сайт 1х)

“Жинхэнэ эр хүний” үзэл санааны тухай ярих юм бол боловсролын зорилго өөр байна. Гэхдээ эцэг эхчүүд өөртөө итгэлтэй, бие даасан хүнийг хүмүүжүүлэх нь чухал бөгөөд үлдсэнийг нь хувь хүн өөрөө шийднэ. (2) “Жинхэнэ эр хүн хүйтэн харцтай, овчарка (German shepherd) эсвэл банхар нохойтой байх ёстой юм шиг бусад хүмүүс санадаг. Гэхдээ эцэг эхчүүд хүүгээсээ илүү хүчирхэг хүйсийн зохистой төлөөлөгчийг өсгөн хүмүүжүүлэх зорилгоо тавихдаа энэ тухай огтхон ч боддоггүй. Эцэг эхчүүд хүүхдээ өөртөө итгэлтэй, биеэ даасан хүн болж нийгэмд зохистой байр суурь эзлэхэд нь туслах чанаруудыг хөгжүүлэхийг эрмэлзэх хэрэгтэй” (Сайт 1х). (3) “Жинхэнэ эр хүн юу хүсч байгаагаа тодорхой мэдэж, өөртөө зорилго тавьж, түүнийгээ хэрэгжүүлэх чадвартай байхаас гадна гаргасан бүх шийдвэртээ хариуцлага хүлээхэд бэлэн байх ёстой. Жинхэнэ эр хүн хүсэл зорилготой, шүүмжтэй, үйлдэлдээ зарчимч, бусад найддаггүй, бүх асуудлыг өөрийнхөөрөө шийдэж хэвшсэн байдаг” (Сайт 1х). (4) “Хүсэл эрмэлзэлгүй, зорилгогүй эр хүнийг найдвартай, эрэлхэг гэж нэрлэж болохгүй. Жинхэнэ эр хүн шийдэмгий, зоригтой байж, шийдвэр гаргаж, байр сууриа хамгаалж чаддаг байх ёстой” гэжээ. (Сайт 1х)

Тэд ирээдүйн эр хүнийг цэвэрч, нийтэч, бас бие даасан байхыг хүсдэг. (5) “Эрэгтэй хүн зөв дүр төрхтэй байх ёстой, мөн үс засалтаараа ялгардаг байх хэрэгтэй. Бараг ямар ч сэдвээр, ямар ч орчинд яриагаа үргэлжлүүлж чаддаг байх нь биеэ даасан хүний шинж юм.” (Сайт 2х)

Ахмадуудын хувьд хүү нь өөртөө өгөөмөр байх ёстой бөгөөд эмэгтэйчүүдийг хүндэтгэдэг байх нь чухал юм. (6) “Жинхэнэ эр хүн бол эрхэм. Бусад хүмүүсийн зовлон зүдгүүрийг өрөвдөх сэтгэлтэй. Гэхдээ тэрээр тусламж хэрэгтэй байгаа бүх хүнд туслах ёстой гэсэн үг биш. Гэхдээ гэр бүл, найз нөхдөд нь түүний дэмжлэг, анхаарал халамж хэрэгтэй болох үед хэзээ ч татгалзаж болохгүй. Жинхэнэ эр хүн гэр бүлээ, өөрөөсөө ахмад хүмүүсийг үнэлдэг байх ёстой” (Сайт 1х).

Хөвгүүд жижиг шархнаас болж уйлж болохгүй. (7) “бага зэргийн гэмтэл бэртэл болох өвдөгөө цохих, хөхрөлт зэргийг тэвчих хэрэгтэй” (Сайт 2х). Томчууд хөвгүүдийг уйлахыг цээрлэдэг, мөн тэднийг арчаагүй байж болохгүй, эрэгтэй хүн өөртөө л итгэх ёстой гэж сургадаг нь олон зүйл дээр анзаарагддаг. (8) “Ирээдүйн хүн стресс, өвдөлтийг хэрхэн тэсвэрлэхээ мэддэг байх нь чухал. Хэрэв та эрэгтэй хүүхдийг өсгөж байгаа бол түүнийг унаж, бусад хүүхэдтэй зодолдох үед нь өмөөрч урдуур нь орж болохгүй. Ирээдүйн эр хүн уйлж, гомдоллодоггүй байх ёстой.” (Сайт 3х)

Хөвгүүдийн хувьд бие махбодийн болон оюун санааны чанарыг хөгжүүлэх шаардлагатай гэсэн ойлголтууд нийгэмд байдаг. Спорт нь бусдыг хүндлэх, хувийн сахилга бат, хүсэл эрмэлзлэл болон өрсөлдөх чадвар төлөвшүүлэхэд хувь хүнд чухал үүрэгтэй. (9) “Хөнгөн атлетик, усанд сэлэх, тулааны урлаг, бүжиглэх спорт, оюун санаа хөгжүүлэх сургалтууд хөвгүүдийн цаашдын хөгжилд зайлшгүй байх хэрэгтэй. Тулааны урлаг нь хөвгүүдэд эр зориг, хувийн сахилга бат, ирээдүйн удирдагчийн хүсэл зориг, өөрийгөө ухамсарлах чадварыг хөгжүүлэхэд тус болох болно. Тамирчдын дундаас амжилттай бизнес эрхэлдэг олон хүмүүс гарч ирдэг бөгөөд хөвгүүдийн спорт сонголт нь түүний ирээдүйн хувийн чанаруудын үндэс суурийг тавьж өгсөн байдаг”(Сайт 3х).

Эрэгтэйчүүд хайртай хүмүүсээ, ялангуяа эмэгтэйчүүдийг зоригтойгоор хамгаалах чадвартай байх ёстой; түүний баатар нь байх ёстой. Хамгаалагч байх нь эр хүний амьдралын үүрэг. (10) “Хөвгүүд харанхуй өрөөнд ганцаараа унтахаас айдаггүй, охины төлөө алхам хийхдээ айдаггүй, тэр байтугай ард түмнийхээ төлөө зогсохоос айдаггүй байх үүрэгтэй. Ийм дүр төрхийг нь зоригтон гэж нэрлэдэг. Энэ нь хөвгүүд айдсын мэдрэмжийг мэддэггүй гэсэн үг биш, харин эрэгтэй хүн “би айж байна – би айхгүй байна” гэхээсээ илүүтэйгээр хүчтэй байж, эрэгтэй хүний шинж чанарыг ойлгосон байх нь чухал” (Сайт 3х).

### **Хэлэлцэмж**

Төгс охидын шинж чанарыг нэгтгэн дүгнэж хэлэхэд бид боловсролын салбарт орчин үеийн талыг олсон гэж хэлж болох ч охид илүү шинэлэг үнэт зүйлстэй болжээ. Орчин үеийн хүмүүсийн хувьд тэд уламжлалт эмэгтэйлэг чанарыг орхиж, эрэгтэй хүний зан чанаруудын ертөнцөд шилжиж, охидод өөрсдийн сонирхолыг олох боломжийг нээлттэй болгож (жишээлбэл, хөл бөмбөг тоглох), охидод манлайлах чанарыг тодорхой хэмжээнд боломжтой болгожээ. Өмнө нь хязгаарлагдмал байсан зарим нэг хэвшмэл ойлголтуудыг дагаж мөрдөхгүй байх болмжтой болжээ. Уламжлалт

талаас нь авч үзвэл үзэсгэлэнтэй эмэгтэй, гэрийн эзэгтэй, ээж эмэгтэй буюу өөртөө болон гэр бүлдээ анхаарал халамж тавих, эхнэр хүний эелдэг байдал, нөхөртөө дуулгавартай байх, эрдэм мэдлэгтэй байх зэрэг “хамгийн төгс эмэгтэй”-н дээрх шинж чанаруудыг эрхэмлэдэг хэвээр байна.

Тиймээс бид эмэгтэйчүүдийн тухай дараах таван шинж чанар нийгэмд байр суурь эзэлсэн хэвээр байгааг олж мэдлээ. Үүнд:

(1) эхийн үүрэг: хэмнэлттэй байдал, гэр орноо авч явах, нөхөртөө дуулгавартай байх;

(2) үзэсгэлэнтэй дүр төрх: дотоод өөрийгөө үнэлэх үнэлэмж, эмэгтэйлэг байдал, нигүүлсэл, баяр баясгалан, бие махбоддоо анхаарал халамж тавих, цэвэр ариун байдал, эрүүл ахуй;

(3) сайхан сэтгэл: эелдэг байдал, өршөөл, мэдрэмж, өрөвч сэтгэл, эелдэг байдал, түүнчлэн халамжтай;

(4) мэдлэг: үүнд боловсрол, оюун ухаан, үндэслэлтэй байдал, нийтэч байдал;

(5) эрх мэдэл, манлайллыг багтаасан хувь хүн.

Харин хамгийн тохиромжтой хөвгүүдийн шинж чанарыг нэгтгэн дүгнэж үзвэл, хөвгүүдийг илүү хүчтэй хүйсийн төлөөлөгч гэж үздэг хэвээр байгаа бөгөөд тэднээс насанд хүрсэн хойноо эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгшин хүмүүсийг хамгаалах ёстой үзэл баримтлал өнөө цагт ч буй нь харагдаж байна. Эрэгтэй хүний хамгийн чухал шинж чанар нь: зорилготой байх, бие даасан байх, тэд шийдвэр гаргаж, үр дагаварт нь хариуцлага хүлээх чадвартай байх хэрэгтэй.

Харин энэхүү өгүүлэлийн хүрээнд бид олсон шинж чанаруудаа дараах таван бүлэгт нэгтгэв:

(1) зорилго: сахилга бат, шийдэмгий байдал, хариуцлага (өөрөөр хэлбэл зохистой шийдвэр гаргах чадвар), бодитой, логик сэтгэлгээ, амжилттай байх;

(2) бие даасан байдал: өөртөө итгэх итгэл, бие даах чадвар, манлайлал зэргийг багтаах;

(3) эр зориг: үүнд айдас, мэдрэмжийг удирдах, хамгаалагч, баатрын үүрэг;

(4) нинжин сэтгэл: анхаарал халамж, мэдрэмж, өгөөмөр, эелдэг байдал, цэвэр цэмцгэр байдал, нийтэч байдал, эмэгтэйчүүд, хөгшин хүмүүсийг хүндэтгэх;

(5) үйл ажиллагаа: үүнд бие бялдрын хөгжил, эрүүл мэнд, хичээл зүтгэл, аз жаргал, сонирхол зэрэг орж байна.

### ***Дүгнэлт***

Эцэст нь бид судалгааныхаа асуултуудаа эргэн харвал: Нэгдүгээрт: Охид, хөвгүүдтэй холбоотой ямар үг хэллэг, яриа ашиглагддаг вэ? Хоёрдугаарт: Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүргийн талаар ямар санаанууд нийтлэг байдаг бэ? Гуравдугаарт: Хүүхэд хүмүүжүүлэхэд хүйс ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? Дөрөвдүгээрт: эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн жендэрийн үүрэг, жендэрийн боловсролын хооронд ямар хамаарал байна вэ?

Дүгнэж хэлэхэд, **нэгдүгээрт**, монголд охид, хөвгүүдийн талаар янз бүрийн яриа хэлцэл ашигладаг гэж хэлж болно. **Хоёрдугаарт**, бид монголын нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүргийн талаар боловсролын үүднээс судалж, ирээдүйн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хүлээлт, хүйсээс хамааран бие биенээсээ эрс ялгаатай болох нь тодорхой болгох хэрэгтэй. **Гуравдугаарт**, Монгол улсад хүйс нь хүүхдийн хүмүүжилд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг хэвээр байна гэж дүгнэж байна. Охид, хөвгүүдийг хүмүүжүүлэх нь салшгүй зүйл боловч охидийн хүмүүжлийн талаархи уламжлалт болон орчин үеийн илүү үзэл баримтлал байна. **Дөрөвдүгээрт**, энэ ажилд бид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн жендэрийн үүрэг, жендэрийн боловсролын тухай бага авч үзсэн ч эдгээрийн хоорондын уялдаа холбоо байна. Монголын нийгэм дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүргийн талаархи санаа бодлыг судлахын тулд шинэ өгүүлэл, судалгаа хийх шаардлагатай болно.

Бодит байдал дээр нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн өөр өөр дүр төрх гарч ирэх боломжтой гэдгийг бид нэмж хэлэх нь зүйтэй. Чухам энэ асуулт бидний сонирхлыг татаж байгаа бөгөөд цаашид бид ажлаа үргэлжлүүлбэл насанд хүрэгчдийн хүйсийн үүргийг эрэгтэй, эмэгтэй тус тусад нь судлах нь илүү үр дүнтэй байх болов уу. Дараа нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дүрийг боловсролын үзэл баримтлалтай харьцуулж, боловсролын үзэл санаа хэрэгжиж байгаа эсэх талаар дүгнэлт хийж болно.

Илүү их судалж болох өөр нэг тал бол эмэгтэй манлайлалын сэдэв. Учир нь Монгол улсад дээд боловсролд жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль, эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй хэвээр байна. Охидын манлайллын чанарыг эрэгтэй хүүхэд шиг дэмждэггүй. Жишээнүүдээс харахад бага наснаасаа охидын ийм чанарууд нь спортоор хичээллэх эсвэл өөрийгөө хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үздэг. Ажил

амьдралдаа эмэгтэйчүүд олон зүйлийг хийх чадвартай мэт харагддаг ч шийдвэр гаргаж, хүндэтгэлийн үг хэлэх эрхгүй байдаг.

Монголд 21-р зуунд тэгш байдлын тухай их ярих болсон ч таамаглаж байсанчлан барууны зарчмуудыг бүрэн хүлээн зөвшөөрөх боломжгүй байна. Феминист хөдөлгөөний янз бүрийн асуудлыг анхааралтай авч үздэг ч хүйсийн хандлага аажмаар өөрчлөгдөнө гэж найдаж байна.

Ном зүй

(2015). *Child Marriage in Albania*. Shtypshkronja “Natyra”.

Анн Гордон, Жерри Л.Миллер. (2005). *When Stereotypes Collide: Race/Ethnicity, Gender, and Videostyle in Congressional Campaigns (Frontiers in Political Communication)*. Peter Lang Inc., International Academic.

Арчер, 2006; Миллер & Халперн, 2014; Воод & Ийгли, 2002. (огноо байхгүй).

Ливиа Гершон. (2021 оны April 19). *Улс төр ба түүх*. JSTOR Daily: <https://daily.jstor.org/polygamy-native-societies-and-spanish-colonists/>-ээс Гаргасан

М., Х. (1973). *Explorations in the functions of language*. London: Edward Arnold.

Мони Жон, Анке Эрхардт. (1972). *Эрэгтэй, эмэгтэй, хөвгүүд, охид: Жирэмслэлтээс төлөвших хүртэлх хүйсийн өвөрмөц байдлын ялгаа ба диморфизм*. Baltimore, Maryland: Johns Hopkins University Press.

Рүд, К. (2018). *Religion and Public Life*. Harvard Education: <https://rpl.hds.harvard.edu/religion-context/case-studies/gender/third-gender-and-hijras>-ээс Гаргасан

Фэрклоу Норман. (1995). *Critical Discourse a Хэлний шүүмжлэлийн судалгаанд дүн шинжилгээ хийх*. New York: Longman.